

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/074/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2025 он

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Д.Даариймаа
Утас: 70342495 Цахим хаяг:
daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.21

№ 113

танай

ны №

т

Баяннуур сумын засаг даргын
тамгын газрын дарга
Д.ЖИГМЭД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 6.0, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 176.0 сая төгрөг нийт 182.0 сая төгрөгөөр хөрөнгийн орлогын хөдөлгөөн хийгдсэн байна

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

632502186

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Баяннуур сумын ЗДТГ нь өмнөх онтой хариуцуулахад цалингийн зардал 193.9 сая төгрөгөөр өссөн цалингийн шатлал нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Бусад асуудлын хэсэг

Баяннуур сумын ЗДТГ-ын 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 зорилт 45 арга хэмжээний хэрэгжилт 88.6 хувиар дүгнэгдэж хөтөлбөр арга хэмжээнд зориулан 951.1 сая төгрөгийг төсөв батлагдаж гүйцэтгэлээр 90.8 хувийг зарцуулсан байна.

Баяннуур сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	216,055.01	13,261,394.36
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,427,349,519.58	2,462,313,323.46
Нийт хөрөнгийн дүн	2,427,565,574.59	2,475,574,717.82
Нийт өр төлбөрийн дүн	-	935,000.00
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,427,565,574.59	2,474,639,717.82
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,427,565,574.59	2,475,574,717.82
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,258,466,782.25	1,133,309,378.47
Үйл ажиллагааны зардлын дүн	778,482,730.53	1,086,235,235.24
Үйл ажиллагааны үр дүн	479,984,051.72	47,074,143.23
Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	382,499,938.14	47,074,143.23
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		2,427,565,574.59
Тайлант оны үр дүн		47,074,143.23
Эцсийн үлдэгдэл		2,474,639,717.82
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	879,782,766.00	1,026,629,200.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	654,647,564.00	1,020,544,400.00
Үйл ажиллагааны ЦМГ	225,135,202.00	6,084,800.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(225,135,202.00)	(6,084,800.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,024,859,600.00	865,194,747.59
Урсгал зардал	1,024,859,600.00	859,109,947.59
Хөрөнгийн зардал	-	6,084,800.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	120,865,000.00	951,941,900.00
Улсын төсвөөс санхүүжих	120,865,000.00	951,171,900.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	770,000.00

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засаг даргын Тамгын газар нь УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газар болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглэл болгон ажиллаж байна.

Зорилго: Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, иргэдийнхээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Зорилт:

Сумын Засаг даргын Тамгын газар нь хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах,

Сумын нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах,

Захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй захиргааны үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилт тавин ажиллсан байна.

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

Баяннуур сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баяннуур сумын ЗДТГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,800.0 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Тав. Аудитын гол асуудал

Баяннуур сумын ЗДТГ нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 760,639.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 951,171.9 мянган төгрөгөөр буюу 190,532.9 мянган төгрөгөөр өсгөн баталжээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 45 арга хэмжээг санхүүжүүлэхээр 951,171.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, гүйцэтгэлээр 864,424.8 мянган төгрөг буюу төсвийн 90.8 хувь зарцуулж 86,747.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулиар цахим хуудсанд мэдээлэхээр заасан мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 951,171.9, зарлагын 8 гүйлгээний 72,958.6 мянган мэдээллийг байршуулсан, мөн өмч хөрөнгөтэй холбоотой 13 тушаал шийдвэр мэдээлсэн байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,779.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 8,195.0 мянган төгрөгийн 2 Төлбөрийн акт, 1,584.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

8.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 2 албан хаагчид таван жилийн тэтгэмжийг олгохдоо 2024 оны 4 дүгээр сарын цалинг дотоод журамд заасан хугацаанаас өмнө олгож сарын үндсэн цалинг нэмж тооцон 473,000.0 (дөрвөн зуун далан гурван мянга) төгрөгийг илүү олгосон байна.

2. Тайлант онд төсвийн хөрөнгөөс 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн Бугат, Дашинчилэн, Рашаант суманд нийт 1,500,000.0 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг хандивласан байна.

3. Тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг тасралтгүй 60 сар ажилласан албан хаагчид олгохоос 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/06 тушаалаар Төрийн Захиргааны жинхэнэ албан хаагчаар томилогдсон хүнд түр томилсон хугацааг оруулан 6,222,000.0 (зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга) төгрөгийг тооцож олгосон байна.

8.2 Албан шаардлага Байхгүй

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Үндсэн хөрөнгийн дансанд 243,161,127.0 төгрөгийн 32 нэр төрлийн хөрөнгө үлдэх өртөггүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 32 нэр төрлийн 243,161.1 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дүгээр сарын 25-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 2 албан хаагчид таван жилийн тэтгэмжийг олгохдоо 2024 оны 4 дүгээр сарын цалинг дотоод журамд заасан хугацаанаас өмнө олгож сарын үндсэн	1	473.0	1	473.0	0	0	0	0	0	0	0	0

цалинг нэмж тооцон 473,000.0 төгрөгийг илүү олгосон												
Тайлант онд төсвийн хөрөнгөөс 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн Бугат, Дашинчилэн, Рашаант суманд нийт 1,500,000.0 төгрөгийг хандивласан	1	1,500.0	1	1,500.0	0	0	0	0	0	0	0	0
Тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг тасралтгүй 60 сар ажилласан албан хаагчид олгохоос 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/06 тушаалаар Төрийн Захиргааны жинхэнэ албан хаагчаар томилогдсон хүнд түр томилсон хугацааг оруулан 6,222,000.0 төгрөгийг тооцож олгосон	1	6,222.0	1	6,222.0	0	0	0	0	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн дансанд 243,161,127.0 төгрөгийн 32 нэр төрлийн хөрөнгө үлдэх өртөггүй байна.							1	243,161.1				
Дүн	3	8,195.0	0	0	0	0	1	243,161.1	0	0	0	0